



GLENVIEW SCHOOL DISTRICT 34

1401 Greenwood Road
Glenview, Illinois 60026
www.glenview34.org

ХООЛ ХҮНСНИЙ УДИРДАМЖ

Glenview 34-р Дүүргийн сургуулиуд сурагчдынхаа эрүүл аж төрөх, амьдралын хэв маягийг үргэлжлүүлэн дэмжин ажиллаж байна. Wellness Policy нь сурагчдад эрүүл хооллолтын талаар мэдлэг олгох, хүүхдийн таргалалтыг бууруулахад туслах зорилгоор батлагдсан юм.

ТӨРСӨНӨДРИЙН БАЯРЫГ ХООЛ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНГҮЙ ТЭМДЭГЛЭХ

34-р Дүүрэг нь сургууль дээр төрсөнөдрийн баярыг хоол хүнс, уух зүйлтэй тэмдэглэхийг хориглодог. Тиймээс төрсөнөдрөө хоол хүнсгүй тэмдэглэхийг хүсэж байгаа эцэг эх, хүүхдүүддээ зориулан дараах хэд хэдэн зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

- Хичээлийн үеэр тусгай цаг гаргах/онцгой нэгнийг зарлах цаг байх. Жишээ нь сурагч ангийн хандаа ном уншиж өгөх, өөрийн хөтүхэй түүхийг ангийн хандаа хуваалцах эсвэл багшийн өгсөн жагсаалтаас ямар нэгэн хөгжилтэй үйл ажиллагааг сонгох зэрэг байж болно.
- Ангийн номын санд зориулж ном худалдаж авах. Энэ нь номын урд талын нүүрэн дээр сурагчын нэрийг бичиж, төрсөнөдрийн бэлэг болгон өгсөнийг тэмдэглэх.
- Хүнсний бус зүйл/үдэшлэгт зориулж (харандаа, баллуур, наалддаг цаас) авчирах. Ямар нэгэн эмх замбараагүй байдал үүсгэх зүйл авчирахгүй байхыг хүсье. Хэрэв танд тусламж хэрэгтэй бол сургуультай холбоо барьж чиглүүлэг авна уу.
- Завсарлагаанаар анги дотроо тоглох тоглоом хандивлах.

Бүх баяр ёслолын үйл ажиллагааг ангийн багштай урьдчилан тохирч, ямар ч хоол хүнс, уух ундааны зүйл хэрэглэхийг хориглоно. Дүүргийн хэмжээнд захиргааны ажилтнууд энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

ТӨРСӨНӨДРӨӨС БУСАД БАЯР ЁСЛОЛЫГ ХЭРХЭН



GLENVIEW SCHOOL DISTRICT 34

1401 Greenwood Road
Glenview, Illinois 60026
www.glenview34.org

ТЭМДЭГЛЭХ ХООЛ, ХҮНСНИЙ УДИРДАМЖ

Хоол хүнс, уух зүйл нь төрсөн өдрийн баяраас бусад баярыг тэмдэглэх Halloween болон баярын арга хэмжээний нэг хэсэг байж болно. Гэвч эдгээр хоол, хүнс, ундааны бүтээгдэхүүн нь Хүнсний Үйлчилгээний газраас боловсруулсан цэсийн дагуу сонгогдсон байна.

Эдгээр зүйлс нь Үндэсний хэмжээнд сургуулийн үдийн цайны хөтөлбөрийн зохистой зуушны стандартад нийцсэн байх ёстой. Хэрэв РТА нь хоол хүнсийг худалдаж авахаар шийдсэн бол цэсийн дагуу сонголт хийнэ. Энэ нь хоол хүнс/уух зүйл нь тэжээллэг, тэнцвэртэй байдлыг хадгалсан, хүн бүрт тохирсон сонголтыг санал болгодог. Эдгээр баяр ёслолын үеэр авчирсан аливаа хоол, хүнсийг дэлгүүрээс худалдаж авсан, анхны сав баглаа боодолтой байх ёстой. Гэрийн аргаар хийсэн хоол хүнсний зүйлийг зөвшөөрөхгүй.

Хэрэв танд энэ өөрчлөлттэй холбоотой асуулт, сэтгэгдэл байвал сургуулийн захирал эсвэл Дүүргийн албаны (847) 998-5000 дугаарт холбогдож асууна уу.